СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **2** | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ** | | | | | | | |
| | Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан болон Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хэрэгжүүлж ажиллах ажлыг зохион байгуулан иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг өгөх, орлогыг бүртгэж тэтгэвэр тэтгэмж бусад зардлуудыг олгож, тайлан мэдээг хуулийн хугацаанд гарган тайлагнаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлэн ажиллаж байна. Мөн нийгмийн даатгалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2024 оноос мөрдөгдөж эхэлсэн шинээр батлагдсан Засгийн газрын тогтоол 10, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал 3, Хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын тушаал 9 ХНХ-ын сайдын албан даалгавар-1, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар өгсөн 17 үүрэг даалгавар, зөвлөмж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг гаргаж тайлбар, судалгаа мэдээлэл хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан. | |
| 1.1.2 | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоог 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлэх; | 2023 онд нийт 9314 хүнийг сайн дурын даатгалд хамруулав. | Сайн дурын даатгуулагч албан бус хөдөлмөр эрхчлэгчдийг шинээр хамруулах тоог өмнөх оноос 1843 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | 2023 оны байдлаар 9314 сайн дурын даатгуулагч бүртгэлтэй байсан бөгөөд 2024 онд 1932 даатгуулагчийг хамруулж биелэлт 100,5 хувь, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх 1502 бүртгэлтэй байсан бөгөөд 263 даатгуулагчийг хамруулж биелэлт 115,8 хувь, малчин 2023 онд 3 бүртгэлтэй байснаас 6 даатгуулагчийг хамруулж биелэлт 200 хувь, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг 2023 онд даатгалд хамрагдаагүй байсан бөгөөд Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс 611 даатгуулагчийн судалгааг авч 451 даатгуулагчийг 100,1 хувиар тус тус биелүүлэн ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2023 онд нийт 7,198, 172,508 хүнийг албан журмын даатгалд хамруулав. | Ажил олгогчийн тоог 790, даатгуулагчийн тоог 4641 нэмэгдүүлж төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оныг ”Хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан төлөвлөгөө гарган мөн “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл”-ийг ААН байгууллагад сурталчлах, зорилгоор 5 удаагийн сургалт хийсэн. Тус дүүргийн 38 барилга, оффист үйл ажиллагаа явуулж буй 1057 аж ахуй нэгжид нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулж бүртгэлгүй ажил олгогчдыг илрүүлэн хамруулж тэмдэглэл үйлдэн 473 ААН байгууллагын 5521 даатгуулагч шинээр хамруулж сургалт зохион байгуулсны үр дүнд 2024 онд жилийн эцсийн байдлаар шинээр 793 ажил олгогч, 7198 албан журмын даатгуулагчийг хамруулан ажилласан.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Даатгалтай иргэн” арга хэмжээг 2024 оны 11 сарын 11 ний өдрөөс 15 ны хооронд 1-20-р хороонд ажиллаж сайн дурын даатгуулагч болон албан журмын даатгалд нийт 182 даатгуулагч хамруулсан. | |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| | Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 520,933.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 220,707.9 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Тогтоолын хэрэгжилтийг ханган батлагдсан 697,7 тэрбум төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 2024 онд 697,7 тэрбум төгрөгийн төлөвлөгөөнөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 697,7 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулна гэж тооцон 268,9 тэрбум төгрөгийн зарлагын төсвөөс 267,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, төсвийг зориулалтын дагуу зарцуулан гүйцэтгэлд хяналт тавин төсвийн сахилга батыг ханган ажилласан. Ажилгүйдлийн даатгалын санд 1250,0 сая төгрөг, ҮОМШӨ даатгалын сангийн хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжийн зардал 155,0 сая төгрөг, Тэтгэврийн даатгалын сангаас 2200,0 сая төгрөг хэтрэх нөхцөл байдал үүссэнийг НДЕГ-т төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах, тодотгох төсвийн саналаа 4 удаа хүргүүлсэн. 2024 онд Нийгмийн даатгалын санд НДЕГ-ын даргын тушаалаар 8 удаа төсвийн хуваарьт зардлыг ангилал хооронд шилжүүлэн, урагшлуулж төсвийн зохицуулалт хийсэн ба хамгийн сүүлд НДЕГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны А/202 тоот тушаалын дагуу сангийн төсвийн хуваарьт тодотгол хийгдсэн. | |
| 2.1.2 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай | | Нийгмийн даатгалын | Нийгмийн даатгалын | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | | байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1,693,6 сая төгрөг зарцуулсан. | ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | 2024 оны төсвийн хуваарьт батлагдсан 2551,8 сая төгрөгийн урсгал зардлаас жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2500,0 сая төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин төсвийн сахилга батыг ханган 50,0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан.<br>2024 оны төсвийн хуваарьт цалин хөлс, урамшуулал, тогтмол зардлууд, унаа хоолны нөхөн төлбөр өөрчлөгдөх, нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлүүдийн өөрчлөлтүүдэд НДЕГ-ын даргын тушаалаар 7 удаа төсвийн хуваарьт өөрчлөлт орон тодотгосон.<br>Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Орон нутгийн төсвийн нэмэлт санхүүжилтээр шийдэгдсэн 45,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дансанд бүртгэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан мэдээллийн санд бүрэн байршуулсан.<br>Дээрх хөрөнгө оруулалтын зардлаас 7,3 сая төгрөгийн зардлыг шууд худалдан авалтын гэрээ байгуулан ажил хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн актуудын дагуу зардлыг шилжүүлсэн ба 38,5 сая төгрөгийн зардлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар нээлттэй тендер зарлан, тендерт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгарсан “Гарааны хос технологи” ХХК-тай гэрээ байгуулан зардлыг шилжүүлсэн. | |
| 2.1.3 | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | Батлагдсан 515,484,713.4 төгрөгийн төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 520,883,372.47 төгрөгөөр буюу 101.1 хувиар биелүүлсэн. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын санд 639,315,558.9 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын сангийн төсвийн тодотголоор 697,7 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөнөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 94,8 хувийн биелэлттэй байгаа бөгөөд 2024 оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлнэ гэсэн зорилт тавин ажиллаж байна. | |
| 2.1.4 | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого 97,496,092.58 төгрөг төвлөрч 111.9 хувиар биелүүлж ажилласан байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 137,9 сая төгрөгийн жигд хангаж биелүүлж 2024 оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 100 хувь бүрдүүлэх зорилтыг тавин ажиллаж байна. | |
| 2.1.5 | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс ... хувиар буурсан /өссөн/ байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна. | Тайлант хугацааны эхний авлага 67,509.08 сая төгрөг байснаас 950 ажил олгогчийн 7,240.9 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, 604 ажил олгогчийн 4,876.2 сая төгрөгийн авлагыг хэсэгчлэн барагдуулж, 12,281.3 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | | | | сая төгрөгийн өртэй 41 ажил олгогчид Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 42,889.5 сая төгрөгийн өртэй 1458 ажил олгогчийн арилжааны банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 10,180.4 сая төгрөгийн өртэй 116 ажил олгогчтой авлага барагдуулах гэрээг байгуулан ажилласан. Мөн өндөр нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн 4 байгууллагын авлагыг барагдуулахаар шүүхэд шилжүүлж шийдвэрийг гаргуулж төлөлтийг төлүүлэх арга хэмжээг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллаж байна. Мөн 70 гаруй байгууллагын хаягийг тодруулахаар эрэн сурвалжлах ажиллагаа хийгдэж дараагийн шатны арга хэмжээ авагдаж байгаа болно. | |
| 2.1.6 | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | Сайн дурын даатгуулагчийн өглөгөөс 151 даатгуулагчийн 40,604,566.19 төгрөгийг буцаан олгосон байна. Оны эхний байдлаар 2662 сайн дурын даатгуулагчийн 146.0 сая төгрөгийн өглөгтэй байснаас 108.2 сая төгрөг болгон 85.7 хувиар бууруулсан байна | |
| 2.1.7 | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | Нийгмийн даатгалын сангийн бусад өр авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах зорилт тавин ажиллаж 2023 оны жилийн эцэст бусад авлага 921,8 сая төгрөгөөс 621,8 сая төгрөгийн бусад авлагыг залруулан 67,5 хувиас доошгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелүүлсэн. Нийгмийн даатгалын сангийн бусад өглөг 100,9 сая төгрөгийн оны эхний үлдэгдлийг оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр 50 хувиар бууруулан тайлагнасан. | |
| 2.1.8 | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалын хэрэгжилтийн ханган төвлөрсөн харилцах дансны орлогыг тухай бүх НДЕГ-төв харилцах дансанд шилжүүлэн ажилласан ба 2024 оны 03 дугаар сарын 15-наас Арилжааны банкнуудтай хамтран ажиллах гэрээний дагуу банкнууд өдөр бүр төвлөрсөн харилцах дансны үлдэгдлийг автоматаар төвлөрүүлж байна. Харин төрийн сангийн төвлөрсөн харилцах дансны орлогыг тухай бүр НДЕГ-ын төв төрийн сангийн дансанд тухай бүр шилжүүлэн ажиллаж байна. | |
| 2.1.9 | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 282,436.1 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 282,436.1 сая төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. | Нийгмийн даатгалын сангийн хагас жилийн байдлаар 268,9 тэрбум төгрөгийн батлагдсан зардлыг 268,0 тэрбум төгрөгийг зарцуулан 0,9 тэрбум төгрөгийг хэмнэн зарцуулахаар төлөвлөн зарцуулж байна. Үүнд сан тус бүрээр зарцуулалтыг тооцоолоход:<br>1. Бүх төрлийн тэтгэврийн үндсэн олголтыг гэрээний дагуу сар бүрийн 1-нд харилцагч банкнуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн цахимаар хүргүүлэх шинэ системийн хөгжүүлэлтээс шалтгаалж мэдээллийн санд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ороогүй тэтгэврийн олголтыг нэмэлтээр жагсаалт бэлтгэн сард 4-5 удаа харилцагч банкнуудад цахимаар илгээн нийтдээ тэтгэврийн санд 241,8 тэрбум төгрөгийн зардлаас 241,3 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулж 0,5 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэсэн.<br>2. Тэтгэмжийн даатгалын сангаас ажил олгогч даатгуулагчдын ХЧТА болон ЖА-ын тэтгэмжийн олголтыг тэтгэмжийг гүйлгээний жагсаалтаар 7 хоногт 3-5 удаа гүйлгээ хийн тэтгэмжийн даатгалын санд 15,9 тэрбум төгрөгийн зардлаас 15,5 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулан 0,4 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэсэн.<br>3. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмжийг сар бүрийн 7 хоногт 1 удаа тооцон шилжүүлж 9,1 тэрбум төгрөгийн зардлаас 10,3 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулсан ба төсөв хэтэрсэн асуудлаар НДЕГ-т 3 удаа тодотгол хүссэн судалгааг хүргүүлсэн.<br>4. ҮОМШӨ даатгалын сангаас холбогдох тэтгэвэр тэтгэмжийг хуулийн хугацаанд зардлыг шилжүүлсэн ба 2,0 тэрбум төгрөгийн зардлаас төсвийн хуваарьт багтаан зарцуулсан ба тус газарт тайлан ирүүлдэг “Мон роуд ХХК” –ийн 43 ажилчид ээлж солилцох үеэр осолд орсон тул ҮОМШӨ даатгалын сангийн ХЧТА зардал төсвийн хуваариас | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэтэрсэн тул төсвийн хуваарьт тодотгол хийлгүүлсэн. | |
| 2.1.10 | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 1,726.4 сая төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1,693.6 сая төгрөг зарцуулсан. | а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | 2024 оны газрын үйл ажиллагааны зардлын батлагдсан тодотгосон төсвийн дагуу 2551,8 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын төсвийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу зарцуулан жилийн эцсийн байдлаар 2500,0 сая төгрөгийн зардлыг зарцуулж 51,8 сая төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан.<br>Дээрх батлагдсан 2551,8 сая төгрөгийн урсгал зардлыг төсвийн ангиллын дагуу зарцуулан хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцон өглөг авлага үүсгээгүй ба цалингийн санд батлагдсан орон тоогоор ажилласан.<br>2024 оны 4 дүгээр 1-нээс төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой ажилчдын цалингийн тооцооллыг тухай бүр хийн НДЕГ-т хүргүүлсэн.<br>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтийн горим баримтлан өр авлага үүсгэхгүй байх тал дээр анхааран ажиллаж байна. | 100% |
| 2.1.11. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн | Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон 2024 оны улирлын санхүүгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | тайлангуудыг хуулийн хугацаанд хүргүүлэн тайлагнасан.<br><br>Шинэ системийн нэвтрэлттэй холбогдуулан сангийн сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуучин программаар боловсруулан сангийн болон байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн болон сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сангийн авлага өглөгийн мэдээ, харилцах дансны үлдэгдлийн мэдээ, тэтгэвэр тэтгэмж авагчдын тооны мэдээ, харилцах дансны нэгдсэн товчооны мэдээ зэрэг 8 төрлийн мэдээг бэлтгэн гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Сангийн улирлын тайлан гаргахад холбогдох бүртгэлийг тухай бүр хийн тухайн ажил хариуцсан байцаагч, сан хариуцсан мэргэжилтэн нартай хамтран тооцоо нийлэх, тайлан гаргах хугацааг тусгаж тайлангийн хуваарь гарган газрын даргаар батлуулан хуваарийн дагуу ажилладаг.<br><br>Харилцагч банкнууд тайлант хугацааны дансны үлдэгдлийн баталгаа тогтмол хийж хэвшсэн ба бусад байгууллагатай тооцоо нийлсэн актаар өглөг авлагын үлдэгдлийг баталгаажуулан ажиллаж байна. Сангийн тайланг чанартай, цаг хугацаанд нь үнэн зөв гаргахад анхаарч дээрх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 2.1.12. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;<br>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон | Үндсэн хөрөнгийн хагас жилийн болон жилийн эцсийн тооллого хийх, дүн мэдээг хүргүүлэх ажлыг газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/18 тоот тушаал, 2024 оны 10 дугээр сарын 23-ны А/35 тоот тушаалаар тус тус ажлын хэсэг байгуулан тооллогыг хийж тайланг удирдлагад танилцуулж, төрийн өмчийн тооллогын нэгдсэн системд бүртгэж ажилласан. Тооллогоор 516 ширхэг 1,688,562,263.94 төгрөгийн өртөгтэй, үндсэн хөрөнгийг тоолон баталгаажуулж ажилтан албан хаагчдын картыг шинэчлэн кодлуулж ажиллаа. Актлах хөрөнгөд 57 ширхэг 11554,2 мян төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн.<br><br>Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн дагуу Капитрон банканд 38.5 мкв талбайг хагас жилийн хугацаатайгаар түрээслүүлэн гэрээг дүгнэсэн ба түрээслүүлэх байрны талбайг өөрчлөн 9,66 мкв талбайг түрээслүүлэх гэрээг үйлдэн НДЕГ болон ТӨБЗГ-т баталгаажуулахаар хүргүүлсэн.<br><br>ТӨБЗГ-с тус газрын төрийн өмчийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | журмын дагуу шалгалтад хамрагдан үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалт 89 хувьтай хангалттай үнэлгээгээр дүгнэгдсэн.<br>Хөрөнгийн тооллогын тоон баримт мэдээ тайланг НДЕГ-т хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. | |
| 2.1.13. | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллага, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитыг "Солид Юнити Аудит" ХХК хийж гүйцэтгэсэн ба "Зөрчилгүй" гэж дүгнэгдсэн.<br>Аудитаас өгсөн зөвлөмжийг залруулах болон цаашид үйл ажиллагаанд давтан гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж аудитын зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх төрийн аудитад хүргүүлсэн.<br>Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн мөрөөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>-Ажил гүйцэтгэх гэрээний дагуу гэрээ дүгнэсэн актыг үйлдсэн.<br>-Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалин олгох, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжөөр өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд ажлаас гарсан 2 ажилтны ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын цалинг тооцож олгосон<br>- Гэрээт ажилчдыг уг зөв үзүүлэлтээр тайлагнах тал дээр сар бүр хяналт тавин ажиллаж байгаа<br>Үндэсний аудитын цахим системд аудитын дүгнэлтийн дагуу хийгдсэн ажлын тайланг цахимаар бүрэн оруулсан. | |
| 2.1.14 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.<br>б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Банкнуудтай байгуулсан 2023 оны “Хамтран ажиллах гэрээ”-ний биелэлттэй холбоотой зарим “хангалтгүй” хэрэгжсэн заалтыг цаашид залруулах, холбогдох саналаа НДЕГ-т хүргүүлэн 2024 оны хамтран ажиллах гэрээнд тусган оруулсан. Тухайлбал ойр байршилтай салбараар үйлчлүүлэх, нэр тодорхойгүй гүйлгээний мэдээллийг авах боломжоор хангуулах зэрэг өөрчлөлтийг тусгасан. ХААН банк, Төрийн банк , Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон зэрэг банкнуудтай ажлын уулзалт зохион байгуулж хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх явцад гарч буй алдаа зөрчлийг нэг бүрчлэн хэлэлцэж цаашид тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал тавин тухай бүр залруулан ажиллаж байна. | |
| | Нийгмийн даатгалын сангийн цахим | | Холбогдох хууль тогтоомжийн | Нийгмийн даатгалын | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг | Нийгмийн даатгалын цахим мэдээллийн санг өдөр бүр өөрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.15. | мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | серверт хуулан бүрдүүлж МТТ-д дамжуулж байна. Анхан шатны нягтлан бодох бүртгэлийн баримт бүрдүүлэлтийг үнэн зөв хуулийн дагуу бүрдүүлэх, бүртгэлийн алдаа залруулга гаргахгүй байх тал дээр дараах асуудлууд дээр анхааран ажиллаж байна.Үүнд:<br>-Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлогыг тухай бүрд нь мэдээллийн баазад шивж оруулахдаа холбогдох баримтыг үндэслэн ажил олгогч, даатгуулагчийн нэр, регистр, гүйлгээний код зэргийг үнэн зөв бүртгэсэн эсэхийг шалгаж нэр тодорхойгүй гүйлгээний жагсаалтыг тухай банкнуудад хүргүүлж тодруулах ажлыг зохион байгуулах, сан хариуцсан мэргэжилтэн болон байцаагч ажилтнуудад зааварчилгаа өгч цахим мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна.<br>- Тэтгэвэр, тэтгэмжийн олголт жагсаалт файл бэлтгэх үед тухай банкны олгох тэтгэврийн сард олговол зохих дүнгээр бэлдсэн эсэхийг мөн тэтгэмжийн жагсаалтаар тухайн байгууллагын нэхэмжлэлээр авч, дансны дугаар зөв эсэхийг тодруулж шалгасны дараа гүйлгээ гаргахыг сан хариуцсан мэргэжилтнүүд анхааран ажиллаж байна.<br><br>Шинэ системийн нэвтрэлттэй холбоотой заавар, даалгаврын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу тухай бүр хийж гүйцэтгэж хэвшсэн. | |
| 2.1.16. | “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системийн хэрэгжилт нэвтрэлт 2024 оны 01 сараас эхлэн шинэ системээр хөтөлсөн ба нэвтрэлтийн ажлын хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын системийн хэмжээнд НДЕГ-ын СБГ-ын зохион байгуулж буй ZOOM уулзалтад тухай бүр орж өгсөн чиглэл, даалгавар,зөвлөмжийн дагуу ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг шинэ системд бүртгэж ажиллаж байгаа бөгөөд бүрэн ашиглагдах хэмжээнд хүрээгүй байна.<br><br>2024 оны жилийн тайлангийн бэлтгэл ажлын хүрээнд шинэ системийн сургалт зөвлөгөө өгөх цахим багуудад хамрагдан бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэх. Жира алдааны мэдээлэл авах системээр тухай бүр саналаа хүргүүлэн хамтран ажиллаж байна. | |
| 2.1.17. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн | 2024 оноос эхлэн санхүүгийн шинэ системд шилжсэнтэй холбоотойгоор барагдуулах боломжтой авлага өглөгийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэн баталгаажуулах | | тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | | холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | барагдуулах залруулах, нэр тодорхойгүй залруулах боломжгүй гүйлгээнд Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулж, нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн өглөг авлагын тооцооны үлдэгдлийг сан тус бүрээр гарган эзэн холбогдогч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.<br><br>Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим дотоод сүлжээнд дансны үлдэгдэл, бусад тооцооны үлдэгдлийг баталгаажуулан байршуулсан | |
| 2.1.18 | ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. | а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.<br>б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна.<br>в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ. | ЭМД-ын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлогыг ЭМДЕГ бүрдүүлэх болсонтой холбоотойгоор тус газрын ЭМД-ын арилжааны банкан дахь 5 дансыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны дотор хааж, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.<br><br>2023 оны жилийн эцсээр Эрүүл мэндийн даатгалын 3903 дансны 37,434,506.21 төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан,даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГазар, ННДГазартай тооцоо нийлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | - | | | | 2007 оноос 2023 оны хооронд үүссэн 3303 дансанд бүртгэлтэй 15,145,010.99 төгрөгийн ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ННДГазар, ННДЕГазар хүргүүлэн ажилласан. | |
| | **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | |
| | Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | |
| 3.1.1 | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Shilen.gov.mn сайтад Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд тусгагдсан нийт 48 мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих үүрэг бүхий 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/14 тушаалаар ажлын хэсэг байгуулж нийт 42 мэдээллийг эхний хагас жилийн байдлаар, харин 2024 оны жилийн эцсийн мэдээ, мэдээллийг байршуулж, нийтлэх, шинэчлэх хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/38 тушаалаар байгуулж нийт 56 мэдээллийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байршуулсан. | |
| 3.1.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09- | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу тус газрын холбогдох ажилтан, албан хаагч нар албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэвтрэн, байгууллагын үйл ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | мэдээлэл байршуулсан. | | 20, Нийгмийн даатгалын сангийн 21 төрлийн мэдээллийг тухай бүр, сар, улирал, хагас жил, жил бүрээр үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг Захиргаа, хяналтын хэлтсийн хяналтын байцаагч тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын сангийн 87 мэдээлэл, газрын үйл ажиллагааны 92 мэдээллийг байршуулсан ба төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт дараа сарын 8-ны дотор маягтын дагуу цахимд байршуулан, тухай бүрд нь хяналт тавьж ажиллаж байна. | |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1 | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Нийт 251 ажил олгогчийн 5093 даатгуулагчийг хамруулан, Улсын байцаагчийн актаар 84 ажил олгогчид 200,2 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 63,5 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 116,4 сая төгрөгийн алданги | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | Тус газрын захиргаа, хяналтын хэлтсийн нийт 199 ажил олгогчийн 489 даатгуулагчийг хамруулан, улсын байцаагчийн актаар 97 ажил олгогчид 1,821,4 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 247,3 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 86,8 сая төгрөгийн алданги ногдуулж 334,1 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100% хувь барагдуулаад байна.<br>Дотоодын хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 2024 оны байдлаар шинээр тогтоогдсон 1,178 өндөр насны тэтгэвэр авагчийн 1,403,2 сая төгрөг, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ногдуулж нийт 179,9 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100% хувь барагдуулсан. | | тэжээгчээ алдсаны 30 тэтгэвэр авагчийн 17,6 сая төгрөг, тахир дутуугийн 98 тэтгэвэр авагчийн 58,9 сая төгрөг нийт 1,306 тэтгэвэр авагчийн 1,479,8 сая төгрөгийн тэтгэврийн хувийн хэргийг шалгав. Ажилласан жилийн нэмэгдэл 373 тэтгэвэр авагч хийлгэсэн мөн Хөдөлмөрийн чадвар алдсан 250 тэтгэврийн сунгалт хийлгэсэн өөрчлөлтийг тухай бүр нь хянаж Sikos програмд шийдвэрлэж ажилласан.<br>Мөн ХЧТА -9,593 даатгуулагчийн 4,176,8 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсэн болон амаржсаны 2,038 даатгуулагчийн 7,625,9 сая төгрөгийн, ҮОМШӨ-н ХЧТА-139 даатгуулагчийн 419,3 сая төгрөгийн нийт 11,770 даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг шалгаж 11,914.8 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж олгуулав.<br>Тайлант хугацаанд 290 даатгуулагчдын 1,200,0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийн олголт бодолт болон ажилгүйдлийн даатгалын сангаас 2,039 хүнд олгосон 9,153,5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийн бодолтыг шалгаж ажилласан.<br>2024.01.11-ний өдрийн Газрын даргын баталсан №01 тоот “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого, олголтыг тулган шалгах” ажлын удирдамж дагуу тэтгэвэр олголтын массивын нийт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 23,513-с тайлант оны 22,486 идэвхтэй тэтгэвэр авагчийн 152 шилжиж явсан, 562 нас барсан, 313 зогсоогдсон тэтгэвэр авагчийн нийт 1,027 тэтгэвэр авагчийн хөдөлгөөн бүрээр хэвлэн тулган шалгаж тооллого явуулсан дутуу хувийн хэрэг байхгүй. Илүү олгосон 20 тэтгэвэр авагчийн 6,057,105 төгрөгийн төлбөр зөрчлийг төлүүлэхээр, дутуу олгосон 33 тэтгэвэр авагчийн 5,649,776 төгрөгийн зөрчлийг арилгуулах жагсаалтыг гаргасан.<br>2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн Газрын даргын баталсан №02 тоот "Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах ажлын удирдамж"-ийн дагуу шалгасан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж", Нийгмийн даатгалын ерөнхий газрын 08/2075 албан бичгийн дагуу 62 аж ахуйн нэгж, байгууллагаас 44 байгууллага шалгаж 8 аж ахуй нэгж байгууллагад 44 даатгуулагчтай холбоотой Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн 8 актаар 109,602,054.85 төгрөгийн цалингийн сангаас 24,043,365.59 төгрөгийн шимтгэл 12,000,175.91 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн алданги нийт акт, алданги 36,043,541.5 төгрөг 100% төлүүлсэн.<br>Мөн зөрчилгүй 36 аж ахуй нэгжид улсын байцаагчийн зөвлөмж өгсөн. Зөрчлийн тухай хуулийн дагуу 8 аж ахуй нэгжийг 15,000,000.00 төгрөгөөр торгож торгуулийг бүрэн төлүүлсэн. Үйл ажиллагаа явуулахгүй тайлан өгөөгүй 7 байгууллага, захирал төлөөлөгч нь байхгүй 2 байгууллага, хойшлуулах хүсэлт өгсөн 3 байгууллага, аудитын шалгалт хийгдэж байгаа 2 байгууллага, Дипломат статустай, олон улсын гэрээтэй гэх 4 байгууллага нийт 18 байгууллага шалгуулаагүй байна.<br>Нүүрс тээврийн 12 байгууллагаас 4 байгууллага шалгаж 34 даатгуулагчтай холбоотой Улсын байцаагчийн 4 актаар 187,592,607 төгрөгийн цалингийн сангаас 50,226,771.75 төгрөгийн шимтгэл 25,113,385.88 төгрөгийн алданги нийт акт, алдангиар 75,340,157.63 төгрөг 100% төлүүлсэн. Харин нэг байгууллага Сонгино хайрхан дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй байх боловч нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлгүй, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт бүртгэлтэй нэг байгууллага, нэг байгууллага НДЕГ 2023 оныг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дуустал шалгуулсан. Зөрчлийн тухай хуулийн дагуу 4 аж ахуй нэгжийг 8,000,000.00 төгрөгөөр торгож торгуулийг бүрэн төлүүлсэн. Таван аж ахуй нэгж баримт байхгүй гэсэн тайлбарыг өгч шалгуулаагүй. | |
| 3.2.2 | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон ХШГ-т тайлагнах, Илэрсэн зөрчил, дутагдлын 70 аас доошгүй хувийг барагдуулсан байх | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Манай газрын харилцагчаар Хил хамгаалах цэргийн анги, тусгай салбар бүртгэлгүй тул хяналт шалгалт хийгдээгүй болно. | |
| 3.2.3 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнг эхний хагас жилээр тайлагнаж илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж , шийдвэрлэх | ЗГ-ын 420-р тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөний” дагуу НДЕГ-н Нийгэм хамгааллын Улсын байцаагч Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2021-2023 оны хугацаанд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний сангийн орлого, зарлагыг шалгаж Улсын байцаагчийн актаар 1,5 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.4 | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 03/452 тоот албан бичгээр ирүүлсэн “Уул уурхайн бүтээгдэхүүн олборлогч, тээвэрлэгч зарим аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд НД-ын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн дагуу хийгдэх төлөвлөгөөт шалгалтын нэрсийн жагсаалтад манай газрын харьяа Энержи ресурс ХХК байгаа боловч газрын байцаагч нараас татан оролцуулаагүй байна. | |
| 3.2.5 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | Дотоодын хяналт шалгалт болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 20, 11 дугаар сарын 20-ны өдрийн дотор ХШГ-т хүргүүлнэ. | | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | Дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчил 2024 оны байдлаар:<br>- Тэтгэмжийн даатгалын санд- 59 даатгуулагчийн 21,1 сая төгрөгийн төлбөрөөс 16,3 сая төгрөгийг төлүүлсэн.<br>- Тэтгэврийн даатгалын санд 2024 оны байдлаар шинээр 8 тэтгэвэр авагчтай холбоотой 245,6 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 83,2 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж ажиллаа. Нийт 113 иргэнтэй холбоотой 542,3 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс дүнгээс 194,3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, барагдаагүй төлбөр 348,0 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50% хүртэлх хэмжээгээр суутган төлүүлж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дээд газрын болон хөндлөнгийн хяналт шалгалтаар нийт 90 даатгуулагчтай холбоотой 50,3 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 40,7сая төгрөгийг барагдуулж 9,5 сая төгрөгийг төлбөр зөрчлийг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна.<br>• Үүнд: Тэтгэвэр 71 даатгуулагчийн 45,7 сая төгрөгийн төлбөрөөс 40,5 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж 5,1 сая төгрөг үлдсэн.<br>• Тэтгэмж 18 даатгуулагчтай холбоотой 1,5 сая төгрөгийн зөрчлөөс 200,6 мянган төгрөгийг барагдуулсан.<br>• Ажилгүйдлийн тэтгэмж 1 даатгуулагчтай холбоотой 3,1 сая төгрөгийг барагдуулах ажиллагаа хийгдэж даатгуулагч Баянжаргал нь Монгол улсад байхгүй хамаарал бүхий этгээд олдохгүй байгаа тул эрэн сурвалжлуулахаар хандаад байна. | |
| **ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.1.1 | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна. Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдсэнтэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | | чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | | холбоотойгоор шинээр батлагдсан 4 хууль, 40 гаруй дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>СБДЗД-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 19 арга хэмжээний жилийн биелэлтийг хангаж ажилласан. | |
| 4.1.2 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | 2023 онд иргэдээс ирсэн 120 өргөдөл, Аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 1006 албан бичиг ирснээс хариутай бичгийн тоо 0, хариугүй бичгийн тоо 1006, албан бичгийг 100 хувь шийдвэрлэж ажилласан байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Даатгуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж буй байдлыг түргэн шуурхай зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны байдлаар UB ERP программд бүртгэлтэй нийт 380 өргөдөл ирүүлснээс 376 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 4 өргөдлийг хариу өгөхөөр судалж, харин Able программаар нийт 847 албан бичиг хүлээн авч, 663 албан бичгийг бусад байгууллагад хүргүүлж, илгээж, програмд холбогдоогүй төрийн байгууллагуудад /прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага, цагдаагийн хэлтэс гэх мэт/ цаас болон шуудангаар хүргүүлэн ажилласан.<br>Харин E-doc программд бүртгэлтэй 1056 албан бичгээс цаас болон шуудан, программаар илгээж хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандсан тус газартай холбоотой 100 гомдол, санал, хүсэлт ирснээс 99 шийдвэрлэн, судлагдаж буй нэг хүсэлт байна. | |
| 4.1.3 | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Тус газар нь архивын үйлчилгээг сайжруулах зорилгоор дүүргийн хөрөнгө оруулалтаар 38536000 (Гучин найман сая таван зуун гучин зургаан мянга) төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд үйлчилгээг сайжруулах зорилгоор Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар “Ухаалаг цахим архивын тоног төхөөрөмж болон дагалдах үйлчилгээ худалдан авах”, нийлүүлэх тендерийг шалгаруулах үнэлгээний хороог байгуулан гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу амжилттай сонгон шалгаруулж, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээн авч нийгмийн даатгалын байгууллагын архивын баримтуудыг скайнердаж мэдээллийн сан бүрдүүлэх, чип суулгах зэрэг ажлуудыг хийж эхэлсэн байна. Архивын ажил цахимжиж иргэд даатгуулагчдад хурдан шуурхай үйлчлэх боломж бүрдүүлэх ажлыг шат дараатайгаар хийж байна. | |
| 4.1.4 | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/52 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | тушаалаар тус газар нь 60 ажилтан, албан хаагчдын орон тоогоор батлагдсан бөгөөд томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж тайлагнан ажиллаж байна. Тус газар нь 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Үүнд:<br>-Удирдах албан тушаалтан-6<br>-Гүйцэтгэх албан тушаалтан-51<br>-Гэрээт-4 | |
| 4.1.5 | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Тус газар нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж ажиллахаас гадна ажлын байрны эмх цэгц, иргэд даатгуулагчдад тав тух, таатай орчин бүрдүүлэх, ажлын байрны стандартыг чанд баримтлан, үйлчилгээний чанар, хүртээмж ил тод байдлыг сайжруулж, шуурхай, илүү нээлттэй болгохыг эрхэм зорилго болгон дараах ажлуудыг санаачлан хийсэн.<br>- Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 Олон Улсын стандартыг амжилттай нэвтрүүлж Сүхбаатар дүүрэгтээ энэхүү стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлсэн хоёрдох төрийн байгууллага болж сертификатаа гардан авсан.<br>- Тус газраас нийгмийн даатгалын ач холбогдлыг иргэд, даатгуулагч, ажил олгогчдод таниулан сурталчлах, хамралтыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын тооцоолуурыг санаачлан шинээр цахим системд бий болгосон. /https://ndaatgal.vercel.app/ Тухайн тооцоолуур бий болсноор Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын фейсбүүк пэйж хуудсанд байршуулахад 134661 иргэд, даатгуулагчдад хүрснээс 11270 иргэд, даатгуулагч тус тооцоолуурыг ашиглан өөрийн тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсан, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцоолж үзсэн байна.<br>- Нийгмийн даатгалын “Цахим хөтөч”-ийг тус газрын санаачилгаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэмжлэгтэйгээр AR технологи хөгжүүлэгч АРГУН компаниар хийлгэснээр нийгмийн даатгалын байгууллагуудаар үйлчлүүлж буй ажил олгогч, иргэд, даатгуулагчид “Цахим хөтөч”-өөс мэдээлэл авах боломжтой болсон.<br>-Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын нэг давхарт байрлах ариун цэврийн өрөөг тус газраас нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирсэн иргэд, даатгуулагчид ашигладаг бөгөөд ихэвчлэн өндөр настан, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлдэг боловч зориулалтын бус тоноглолтойгоос дээрх иргэдэд үйлчлүүлэхэд хүндрэл үүсэх тохиолдол гардаг. Иймд тус газрын нэг давхрын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ариун цэврийн өрөөг Сүхбаатар дүүргийн Тамгын газрын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх боломжийг бүрдүүлж тохижуулсан.<br>-Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар, Сүхбаатар дүүргийн тамгын газрын хамтран хэрэгжүүлж буй цэцэрлэгжилтийн аяны хүрээнд ажлын байрны гадаад орчныг тохижуулж хашааг дагуулан мод тарьж, цэцгийн мандал байгуулж өнгө үзэмжийг сайжруулах ажлыг хийлээ. | |
| 4.1.6 | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажиллаж байна. | |
| 4.1.7 | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Тус газрын Улсын байцаагч болон төрийн, үйлчилгээний албан хаагч нартаа Авлигын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, МУИХ-ын байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны №5 тогтоолын дагуу “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг цаг тухай бүрд нь гаргаж, ашиг сонирхлыг зөрчлөөс хамгаалах гэрээг байгуулсан.<br>Мөн газрын төрийн болон үйлчилгээний албан хаагчдад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулах. | | Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн газраас Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтаар ашиг сонирхлын зөрчил болон хувийн, нийтийн ашиг сонирхлын талаар, авлигын тухай ойлголт, албан хаагчдын хуулиар хориглох үйлдэл, хариуцлага хүлээлгэх үндэслэл зэргийн талаар ойлголтыг авч ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. | |
| 4.1.8 | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна. | -Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж ариун цэврийн өрөөг тохижуулсан.<br>-Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 Олон Улсын стандартыг амжилттай нэвтрүүлж Сүхбаатар дүүрэгтээ анхдагч энэхүү стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлсэн хоёрдох төрийн байгууллага болж сертификатаа гардан авсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мөрдөж ажилласан байна | | | | |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.2.1 | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 10 удаагийн сургалтад 335 албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | 2024 оны Сургалтын төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, үйлчилгээний ур чадвар, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор бэлтгэл ажлыг ханган дараах 10 удаагийн сургалтуудад давхардсан тоогоор 89 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Үүнд:<br>- Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт<br>- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт<br>- Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сургалт<br>- Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт<br>- Монгол бичгийн дунд шатны сургалт<br>- Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт<br>- Манлайлал, урч чадварын сургалтад тус тус хамрагдсан<br>- Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх зорилгоор тус газрын Захиргаа, хяналтын хэлтсийн хяналтын улсын байцаагч нар 7 хоногийн турш шинэчилсэн нийгмийн даатгалын багц | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулиар сургалтыг зохион байгуулж хамруулсан болно. | |
| 4.2.2 | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 15 удаагийн сургалтад 2784 иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Даатгалтай иргэн” аяны хүрээнд нийгмийн даатгалын ач холбогдлын талаар таниулах сургалтыг зохион байгуулах ажлыг 10-11 дүгээр сард хуваарь гарган сургалтыг зохион байгуулсан.<br>Газрын сошиал хуудсаар болон мэйл хаягаар ирүүлж буй иргэдийн санал хүсэлт, асуултад хариулж холбогдох хүмүүстэй холбогдож асуудлыг шийдвэрлэх, мэдээллийн баазаас шалгах зэрэг ажлуудыг тогтмол хийж байна.<br>Аж ахуйн нэгж байгууллагуудад багц хуулийн шинэчлэлээр 396 хүнийг хамруулан 16 удаагийн сургалт зохион байгууллаа.<br>Багц хуулийн шинэчлэлээр Ажил олгогчийн зөвлөгөөн зохион байгуулж 200 байгууллын нягтлан бодогч нарыг хамруулсан.<br>СБД-н 11-р хорооны 43 ажилтнууд, хэсгийн ахлагч, иргэдийг хамруулсан багц хуулийн шинэчлэлийн талаар сургалт зохион байгуулсан.<br>Нийгмийн даатгалын “Цахим хөтөч”-ийг тус газрын санаачилгаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэмжлэгтэйгээр AR технологи хөгжүүлэгч АРГУН компаниар хийлгэснээр нийгмийн даатгалын байгууллагуудаар үйлчлүүлж буй ажил олгогч, иргэд, даатгуулагчид | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Цахим хөтөч”-өөс мэдээлэл авах боломжтой болсон. | |
| 4.2.3 | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл,<br>Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо.<br>Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо.<br>Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн нийт 123 постероор 954136 иргэнд 6 удаагийн лайв 69854 иргэнд 1023990 хандалттай байсан. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна.<br>ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | Сүхбаатар дүүргийн албан ёсны сайт 10, тус газрын фэйсбүүк хуудас 46, дүүргийн 1-20 хороодын группт 70 гаруй мэдээллийг давхардсан тоогоор 1468 удаа түгээн, сурталчлан ажилласан<br>Газрын 18000 гаруй дагагчтай пэйж хуудас болон facebook группээр нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлээр 46 постер, 400 гаруй даатгуулагч иргэдийн асуултад хариулсан.<br>Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан Өдөрлөгт амжилттай оролцож 214 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br>Дүүргийн 1-20 дугаар хороодын иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор 15 постерийг давхардсан тоогоор 136 удаа түгээсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | | | | |
| Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх | | | | | | | |
| 4.3.1 | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 448 дүгээр тогтоолоор батлагдсан дүрмийн хэрэгжилтийг бүрэн хангаж, Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн хурлыг тайлант хугацаанд иргэдийг байлцуулахгүйгээр, 100% бичиг баримтад тулгуурлан хуралдаж, нийт 46 удаа хуралдаж, 1912 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнээс 1355 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, жагсаалтын шаардлагад нийцсэн 421 иргэнд өвчний явц, шинжилгээ, үзлэг, өвчтөнд илэрч буй зовуурь өөрчлөлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан шалтгаанаар 133 иргэний хувь, хугацааг цуцлаад байна. 2024 онд тус зөвлөлийн харьяанд 41 хүн шилжин ирж, 44 хүн иргэний харьяаллын дагуу шилжин явж, 59 хүн нас барсан бүртгэлтэй байна.<br>Шинээр батлагдсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмийг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зөвлөлийн хурлыг зохион байгуулж буй ажлын явцыг ЗГ-ын хяналт үнэлгээний газарт танилцуулж, MNB, HDМонгол TV, | |
| | | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна. | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | TV-5 телевизийн сувгуудаар сурталчлан ажилласан.<br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэчилсэн дүрэм, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд баримтлах өвчний шинэчилсэн жагсаалтыг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт танилцуулах сургалтыг хийж, шинэчилсэн жагсаалтыг цаасаар болон цахимаар тарааж, мэдээллээр хангасан. Тайлант хугацаанд зөвлөл нийт 46 удаа, 184 цаг хуралдаж, гишүүдийн хурлын ирц дунджаар 90 хувь байна.<br>Эрүүл мэндийн магадлалын цахим мэдээллийн сангийн бүрдэлд улирал бүр хяналт хийж, даатгуулагчийн хувийн мэдээлэл зөрсөн байх магадлалтай, системийн шинэчлэл хийх бэлтгэл ажлын хүрээнд нас барсан хөдөлгөөн хийгээгүй, иргэний регистрийн дугаар, овог нэр алдаатай шивэгдсэн зэрэг шалтгаанаар нийт 124 хүний мэдээллийг нягтлан шалгах ажлыг хийж дуусгаад байна.<br>Дүүргийн ЭММЗ-ийн жилийн тоон тайланг гаргаж, хууль, дүрэмд заасан хугацаанд багтаан ЭММ-ын Төв зөвлөлд цахимаар болон цаасаар хүргүүлээд байна. Тайлан хугацаанд дүүргийн хэмжээнд ердийн өвчин, ахуйн ослын шалтгаанаар 3097 хүн, ҮО-ын шалтгаанаар 33 хүн, нийт 3130 хүн хөдөлмөрийн чадвар алдаж, 1140 хүн халамжийн сангаас, 1990 хүн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.2 | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд орсон өөрчлөлтийн дагуу иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх хуралд иргэнийг заавал биечлэн байлцуулахгүйгээр шийдвэрлэж хэвшсэн. Тайлант хугацаанд зайлшгүй биечлэн үзлэг хийх 1 тохиолдолд иргэнийг хуралд дуудан ирүүлж, шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна.<br>Түүнчлэн шинээр батлан гаргасан иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх өвчний гарын авлагыг эмч нарт танилцуулж, тогтмол ашиглаж байгаа бөгөөд иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын шийдвэрийг гаргахад оношийн баталгаажилтад зөвхөн зайлшгүй шаардлагатай шинжилгээг шаардаж авснаар иргэнээс илүү шинжилгээ хийлгэхгүй байх, явдал чирэгдэлгүй байхад анхаарч ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлтэй хамтарч ижил мэргэжилтний үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, дүүргийн Эрүүл мэндийн төвөөс нарийн мэргэжлийн 3 эмч, өрхийн 1 эмчийг оролцуулж, бусад 5 аймаг, дүүргийн ижил төстэй 10 картуудад шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргаж, танилцуулах ажлыг цахимаар хийж гүйцэтгэсэн. Ижил мэргэжилтний үнэлгээг зохион байгуулснаар эмч нар хоорондоо санал бодлоо солилцох, маргаантай асуудлаар нэгдсэн нэг ойлголттой болох | |
| | | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна. | | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг нөхцөл бүрдсэн нь сайн тал болсон.<br>Гишүүдийн хурлын ирцийн байдалд 7 хоног бүр тогтмол хяналт тавьж, хуралд оролцсон байдал, нарийн бичгийн даргын гаргасан цагийн тооцооны нэгтгэлийг сар бүр хянаж, зөвлөлийн дарга болон орлогч даргад танилцуулж баталгаажуулж хэвшээд байна.<br>Тайлант хугацаанд зөвлөл нийт 50 удаагийн хурлыг хийх ёстой байснаас 46 удаа, 348 цаг хуралдаж, гишүүдийн хурлын ирц дунджаар 90-ээс дээш хувь байна. Бүх нийтийн амралтын өдөр таарсан, 2023 оны жилийн тоон тайлан нэгтгэж дуусаагүй зэрэг тус зөвлөлийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар 4 удаа зөвлөл хуралдаагүй болно. | |
| 4.3.3 | Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжилтийг хангаж ажиллах | | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана.<br>Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон | Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭММТЗ-д хүргүүлнэ. | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна.<br>Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг хийж дүгнэсэн байна. | Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан нийт 3139 иргэн байгаа нь нийт хүн амын 2.13 хувийг эзэлж байна. Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгааныг судалж үзэхэд мэдрэл, гэмтэл, сэтгэц, нүд, сонсголын эрхтний эмгэг давамгайлж байгаа бөгөөд зүрх судасны эмгэг, хавдрын өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдах тохиолдол мөн тэргүүлэх байранд хэвээр байна. ЭХМК-ын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон, сунгуулсан нийт иргэдийн 15.96%-ийг мэдрэлийн, 14.3%-ийг гэмтлийн, 13.1%-ийг сэтгэцийн, 11.2%-ийг нүдний, 10.5%-ийг сонсголын эмгэгүүд эзэлж байгаа юм. ЭМЯ-наас санаачлан зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна | | | байгуулсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээний ажлын үр дүнд тус дүүргийн хэмжээнд хавдрын өвчлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийн тоо өмнөх 2023 онтой харьцуулахад нэмэгдсэн боловч, 2024 оны байдлаар хавдрын өвчлөл буурсан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон, сунгуулсан иргэдийн өвчлөлийн шалтгааныг судалж үзэхэд иргэдийн амьдралын буруу хэв маяг, буруу хооллолт, эрүүл мэндийн талаар мэдлэг дутуу, эрүүл мэнддээ анхаарал хандуулахгүй байгаа нь өвчлөл үүсэх улмаар хөдөлмөрийн чадвар алдалт үүсэх нөхцөл шалтгаан болж байна. | |
| 4.3.4 | Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон төрөлжсөн мэргэшлийн, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна. | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан цахим сургалтад дүүргийн ЭМТ-ийн эмнэлэг хяналтын комиссын 5, ЭММЗ-ийн 10 гишүүнийг хамруулж, авлигаас сэргийлэх, авлига албан тушаалын гэмт хэргээс сэргийлэх чиглэлээр мэдлэг олгосон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх | | | | | | | |
| 4.4.1 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | 2024 оны жилийн байдлаар 9364 аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагчдын регистрийн дугаарыг улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгаж ажилласан. | |
| 4.4.2 | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Даатгуулагчийн үндсэн мэдээлэл, төрөл, ажил мэргэжлийн ангилал, кодыг тухай бүр шалган ажиллаж байна. | |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | |
| 4.4.3 | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системийн нэвтрэлттэй холбоотой программ хангамжуудын эрхийн тохиргоог байцаагч,нэгж болгоноор үүсгэн шинэ системд ажиллах боломжийг бүрдүүлсэн.<br>Программ хангамж ашиглалт, аюулгүй байдлыг хангаж байцаагч, нэгж болгонд нууц үг, нэвтрэх нэр үүсгэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | МТТ-с зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичиг, ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу байцаагч ажилтнуудад мэдээлэн таниулж шаардлагагтай мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.<br>Шинэ системийн сургалтад тухай бүр хамрагдан нийгмийн даатгалын байгууллагын Мэдээлэл технологийн ажилтнуудын цахим мэдээлэл солилцох хуудсаар бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна. | |

---oOo---